

БАТЛАВ:

ХҮРЭЭЛЭН БУЙ ОРЧНЫ БОДЛОГЫН
ХЭРЭГЖИЛТИЙН ГАЗРЫН ДАРГА

Г.ЭНХМӨНХ

ЗӨВШӨӨРЧ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮҮРЭГ
ХҮЛЭЭСЭН:

“МАНДГОВЬ” ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРАЛ

Ц.БААТАРБИЛЭГ

**“МАНДГОВЬ” ХХК-ИЙН ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЭРДЭНЭ СУМЫН НУТАГТ
ОРШИХ “ШАРТОЛГОЙН АЛТНЫ ҮНДСЭН ОРДЫГ ИЛ БА ДАЛД АРГААР
АШИГЛАХ” ТӨСЛИЙН 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ**

АШИГТ МАЛТМАЛЫН ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР: MV-017585 ТООТ
АЖ АХУЙ НЭГЖ БАЙГУУЛЛАГЫН РЕГИСТРИЙН ДУГААР: 2861852

Хянасан:

ХБОБХГ-ЫН ШИНЖЭЭЧ

Тайлан боловсруулсан:

Байгаль орчны зөвлөх үйлчилгээний “Грийн Зоне Солюшн” ХХК

Захирал /...../ Х.Тэмүүжин /Доктор (Ph.D)/



2025 он

УЛААНБААТАР ХОТ

Агуулга

1.	Төслийн товч танилцуулга.....	1
1.1.	Оршил.....	1
1.2.	Үйл ажиллагаа явагдаж буй газрын засаг, захиргааны харьяалал	1
1.3.	Газарзүйн онцлог	2
1.4.	Ордын геологийн тогтоц.....	3
1.5.	Уулын ажлын ерөнхий төлөвлөлт	3
2.	Байгаль орчин, нийгэм эдийн-засгийн төлөв байдлын товч танилцуулга.	4
2.1.	Байгаль орчны төлөв байдал.....	4
2.1.1.	Газрын гадарга, ландшафт.....	4
2.1.2.	Уур амьсгал	4
2.1.3.	Усны нөөц.....	4
2.1.4.	Хөрс.....	4
2.1.5.	Ургамлан бүрхэвч	4
2.1.6.	Экологийн асуудлууд.....	5
2.2.	Нийгмийн төлөв байдал	5
2.3.	Эдийн засгийн төлөв байдал	5
3.	ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГУЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ.....	6
3.1.	Эрсдэлийн үнэлгээг эрсдэлийн матриц.....	6
3.2.	Эрсдэлийн үнэлгээний хүснэгт	8
4.	БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ 10	
4.1.	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	11
	Гадаргын ба газрын доорхи усны нөөц	12
	Хөрсөн бүрхэвч.....	12
	Газрын хэвлий	12
	Ургамлан нөмрөг	13
	Амьтны аймаг.....	13
4.2.	Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	14
4.3.	Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	15
4.4.	Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	15
4.5.	Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	16

4.6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	18
5. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	19
6. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ	20
7. Эрсдэлийн талаар хэрэгжүүлэх хөтөлбөр	21
7.1. Аюулгүй ажиллагаа	21
7.2. Уурхайн ба үйлдвэрийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа эрсдэлийг талаар тавих шаардлага, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ ..	21
7.3. Үйлдвэрлэлийн осол гэмтэлтэй тэмцэх арга хэмжээнүүд:	21
7.4. Галын аюулгүй ажиллагаа:	22
7.5. Хөдөлмөрийн аюулгүй байдал	22
8. ХАВСРАЛТ	24

Хүснэгт

Хүснэгт 1. Эрсдэлийн үнэлгээний матриц.	6
Хүснэгт 2. Магадлалын үнэлгээний шалгуур.	7
Хүснэгт 3. Үр дагаврын үнэлгээний шалгуур.	7

Зураг

Зураг 1. Шартолгой алтны үндсэн ордын байршил.....	2
Зураг 2. Улаанчулуутын алтны үндсэн ордын талбайн өндөршлийн зураг.....	2



1. Төслийн товч танилцуулга.

1.1. Оршил

Уул уурхай үйлдвэрлэлийн үйл ажиллагааны хүрээлэн буй орчинд учруулах сөрөг нөлөөллийг зөв оновчтой тодорхойлж түүнийг арилгах, багасгах, арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх нь хариуцлагатай уул уурхайн үндсэн зарчмуудын нэг юм.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10-р сарын 29-ний өдрийн А/618 тоот тушаал болон бусад Монгол улсын хууль, журам, тогтоолын шаардлагад нийцүүлсэн бөгөөд компанийн стратеги төлөвлөгөөнд байгаль орчны тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэхэд нэн тэргүүнд хэрэгжүүлэх шаардлагатай ажлуудыг төлөвлөн тусгасан.


Манай байгууллага хууль, дүрэм журам, стандартын хүрээнд тоосжилт бууруулахад ашиглах усны хэмжээг бууруулах, үйлдвэрт ашиглах гадаргын ус болон газар доорх усны харьцааг нэмэгдүүлэх, биологийн задралд ордог бүтээгдэхүүний хэрэглээг нэмэгдүүлэх болон хог хаягдлын дахин боловсруулалтыг сайжруулах замаар байгальд хаях хог хаягдлын хэмжээг бууруулах, хүрээлэн буй орчинд учруулж байгаа сөрөг нөлөөллийг ялангуяа агаар бохирдуулагчийг хянах тогтолцоог нэмэгдүүлэх, хүлэмжийн хийн ялгаралтыг бууруулахад чиглэсэн арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэх зэрэг гол асуудлуудыг байгаль орчны гол шалгууруудаар тодорхойлсон.

Эдгээр стандарт шаардлага, төлөвлөлт, хариуцлагын хүрээнд 2025 онд хэрэгжүүлэх ажлыг тус төлөвлөгөөнд тусгав.


1.2. Үйл ажиллагаа явагдаж буй газрын засаг, захиргааны харьяалал

Улаанчулуутын алтны үндсэн ордын MV-017585 тусгай зөвшөөрөл бүхий талбай (Зураг 1) нь Дорноговь аймгийн Эрдэнэ сумын нутагт 1712.88 га талбайг эзлэн оршдог. Газар зүйн байршлын хувьд Улаанбаатар хотоос зүүн өмнө зүгт 750 км орчим, Сайншанд хотоос зүүн урд зүгт 180 км, Эрдэнэ сумаас урагш 70 км, Улаанбадрах сумаас зүүн зүгт 65 км, Замын-Үүдийн хилийн боомтоос баруун зүгт 65 км, улсын хилээс хойш 55 орчим км-т тус тус оршино Ордын булангийн цэгүүдийн солбицол:

1.	111° 15' 15.00"	43° 52' 58.00"
2.	111° 15' 15.00"	43° 52' 34.86"
3.	111° 17' 10.06"	43° 52' 34.86"
4.	111° 17' 10.05"	43° 51' 33.00"
5.	111° 11' 46.08"	43° 51' 33.00"
6.	111° 11' 46.08"	43° 52' 58.00"



Зураг 1. Шартолгой алтны үндсэн ордын байршил.



Зураг 2. Улаанчулуутын алтны үндсэн ордын талбайн өндөршлийн зураг.

1.3. Газарзүйн онцлог

Ордын талбай нь говийн их мужид хамаарах говийн бэсрэг уулс дунд тэгшивтэр гадарга зонхилсон, намхан хэлхээ уулс, өргөн уудам хөндий тэдгээрийн дунд сунаж



тогтсон жижиг толгодууд нь далайн түвшингээс дээш дунджаар 1100 м -т өргөгдсөн байх бөгөөд хамгийн өндөр цэг нь Улаанчулуут уул 1436.1 м (Зураг 2).

Ус чийг бага, хуурай салхи ихтэй учир ургамлын бүрхэвч тачир сийрэг. Говийн цөлөрхөг хээрийн бүсэд зохицсон ургамал зонхилон ургах ба хазаар, агь, гоёо, таана, бударгана, хөмүүл, эмийн ургамлаас чихэр өвс, цульхир, хулангийн ундаа ургадаг ба бутлаг ургамлаас харгана, шаваг загсгал, модлог ургамлаас хайлаас, тоорой, заг, сухай зэрэг ургадаг.

1.4. Ордын геологийн тогтоц

Тус ордын талбай нь региональ бүтцийн хувьд Өвөр Монголын ба Өмнөд Монголын гэсэн хоёр томоохон атираат системийн хэмжээнд Нүхт даваа, Еншөө, Хутаг уул, Сулинхээрийн бүсэд хамаарна.

Геологийн тогтцын хувьд ордын талбай орчмын ихэнх хэсгийг дунд пермийн дэл-овоот формацын вулканоген-тунамал чулуулаг эзлэх ба хойд хэсгээр хожуу Юрийн Эрдэнэтолгой бүрдлийн улаан ягаан өнгийн жижиг-дунд мөхлөгт шүлтлэг боржингийн биет, баруунаас зүүн хойш суналтай нягт цул, шаравтар саарал, ягаавтар өнгөтэй риолит, риодацитын дэл судлуудаар зүсэгдэж, хил заагийн хувиралд бага зэрэг орсон байдаг. Мөн багахан хэсэгт плейстоцен, голоцены сэвсгэр хурдсаар хучигдана. Давхарга зүй:

- Доод пермийн Байрам-овоо, Харнүдэн формац;
- Дунд пермийн Дэл-овоот формац;
- Дунд-дээд юрийн Эрээн-уул формац;
- Дээд цэрдийн Баянширээ, Баруунгоёот формац;
- Эоцений Хөвсгөл формац;
- Дөрөвдөгчийн (плейстоцен ба голоцений) сэвсгэр хурдас.

1.5. Уулын ажлын ерөнхий төлөвлөлт

Дорноговь аймгийн Эрдэнэ сумын нутаг дахь Шартолгойн алтны үндсэн ордыг хосолсон аргаар ашиглах техник-эдийн засгийн үндэслэлийг (ТЭЗҮ) “Мандговь” ХХК-ийн захиалгаар “Бал чулуу” ХХК-ийн мэргэжилтнүүд боловсруулсан бөгөөд жилд 57.0 мянган тонн хүдэр олборлох хүчин чадалтай байна.

Тус орд нь Галбын говийн цөлөрхөг бүсэд орших бөгөөд А-I, В-I хүдрийн биетүүдийн дээд хэсэгт ил аргаар олборлох боломжтой исэлдлийн бүс (гүн нь 25–35 м, өргөн нь 30–60 м) тогтоогдсон. Ил уурхайн хүрээнд 79.7 кг алт бүхий 42.5 мян.тн хүдрийг 2 жилд олборлож, 657.1 мян.м³ хөрс хуулалт хийгдэхээр төлөвлөсөн. Ашиглалтын 2 дахь жилээс газрын гадаргууд деформацийн аюул үүсэх тул ил уурхайг хааж, далд уурхайгаар үргэлжлүүлэх шийдэл тусгагдсан.



2. Байгаль орчин, нийгэм эдийн-засгийн төлөв байдлын товч танилцуулга.

2.1. Байгаль орчны төлөв байдал

Эрдэнэ сум нь Дорноговь аймгийн баруун урд хэсэгт байрладаг. Сумын газар нутаг нь говийн бүсэд багтах бөгөөд хээрийн болон цөлийн шинж давамгайлсан, хуурай уур амьсгалтай. Сумын нутаг дэвсгэр нь ойролцоогоор 6,800 гаруй км² бөгөөд үүний дийлэнхийг бэлчээрийн газар эзэлдэг.

2.1.1. Газрын гадарга, ландшафт

Эрдэнэ сумын газар нутгийн ихэнх хэсэг нь нам дор говийн хотгор хөндий, элсэрхэг говь, давсархаг нуур, хуурай сайр, жалга зэрэг олон янзын газрын хэлбэртэй. Ландшафтын хувьд уул толгод багатай бөгөөд говийн нам цээл, чулуун хучилттай гүвээ, жижиг бархантай бүс зонхилдог. Хуурай сайрууд нь борооны улиралд түр зуурын урсац бүхий усны голдирол болдог.

2.1.2. Уур амьсгал

Сумын уур амьсгал нь эрс тэс, гандуу, хуурай уур амьсгалын мужид хамаарна. Өвлийн улиралд -25°C хүртэл хүйтэрч, зуны улиралд +35°C хүртэл халдаг. Жилд дунджаар 90-120 хоног хүчтэй салхитай байдаг бөгөөд энэ нь газрын эвдрэл, хөрсний элэгдэлд нөлөөлдөг. Хур тунадасны хэмжээ жилд 100-150 мм бөгөөд ихэвчлэн 6–8-р сард төвлөрдөг. Хүчтэй салхины улмаас элс, шороо шуурч, хөрс салхинд элэгдэх үзэгдэл байнга тохиолддог.

2.1.3. Усны нөөц

Эрдэнэ сум усны нөөц багатай, гүний усны хомсдолтой бүсэд багтдаг. Гол, мөрөн байхгүй бөгөөд байгалийн гаралтай булаг, худгийн усны эх үүсвэрийг ашигладаг. Ундны усны гол эх үүсвэр нь гүний худаг бөгөөд зарим баг сумын төвөөс хол, усны эх үүсвэр хязгаарлагдмал тул усан хангамж хангалтгүй байдаг. Түүнчлэн, газрын доорх усны давсжилт ихтэй, зарим тохиолдолд унданд тохиромжгүй байж болзошгүй.

2.1.4. Хөрс

Сумын нутаг дэвсгэрт голчлон бор хөрс, хүрэн бор хөрс, давсархаг хөрс тархсан. Хөрс нь элсэрхэг, чулуурхаг бүтэцтэй тул ус чийгийг бага хадгалдаг. Малын бэлчээрийн ачаалал ихсэж, бэлчээрийн сэргэх хугацаа удааширснаар хөрсний үржил шим буурч байна. Зарим бүс нутгуудад хөрсний элэгдэл, давсжилт, цөлжилт эрчимтэй явагдаж байна.

2.1.5. Ургамлан бүрхэвч

Ургамлын төрөл зүйл харьцангуй бага бөгөөд ганд тэсвэртэй, хуурай нөхцөлд дасан зохицсон ургамлууд давамгайлдаг. Үүнд ганга, бударгана, хялгана, харгана, хөв хялгана



зэрэг зонхилох ургамлууд ордог. Элсний нүүлт ихтэй газарт ургамлын бүрхэвч сийрэг, зарим хэсэг нь бүрэн нүцгэрсэн байдаг. Хэт бэлчээрлэлт, усны хомсдол, хөрсний доройтол зэрэг хүчин зүйлс нь ургамалжилтад сөргөөр нөлөөлж байна.

2.1.6. Экологийн асуудлууд

Сумын хэмжээнд байгаль орчны тулгамдсан асуудалд:

- Цөлжилт, газрын доройтол,
- Усны нөөцийн хомсдол,
- Бэлчээрийн даац хэтрэлт,
- Ургамлын төрөл зүйлийн хомсдол,
- Элсний нүүлт, хөрсний элэгдэл зэрэг багтдаг.

Эдгээр асуудлууд нь байгалийн нөөцийн тогтвортой ашиглалт, амьжиргааны эх үүсвэр болох мал аж ахуйн салбарт шууд болон шууд бусаар нөлөөлж байна.

2.2. Нийгмийн төлөв байдал

Эрдэнэ сумын нийт хүн ам ойролцоогоор 2340 орчим бөгөөд 700–800 орчим өрх бүртгэлтэй байна. Хүн амын дийлэнх нь мал аж ахуй эрхэлдэг бөгөөд залуучуудын шилжилт хөдөлгөөн өндөр байна. Ихэнх залуус боловсрол, ажил эрхлэлт болон бусад боломжийг эрэлхийлэн аймгийн төв болон нийслэлийг зорьдог байна.

Сумын хэмжээнд ерөнхий боловсролын 12 жилийн сургууль, нэг цэцэрлэг үйл ажиллагаа явуулж байна. Гэвч багшийн хүрэлцээ болон сургалтын орчны хүртээмж сул хэвээр байна.

Эрүүл мэндийн үйлчилгээний хувьд сум дундын эмнэлэг үйл ажиллагаа явуулдаг ч мэргэжлийн боловсон хүчин, тоног төхөөрөмжийн хангалт муу байдаг. Ундны усны чанар болон халдварын эрсдэл өндөр хэвээр байна.

Сумын хэмжээнд утас, интернэт сүлжээ суурин газруудад боломжийн түвшинд хүрсэн боловч алслагдсан багуудад сул байдаг. Нийгмийн халамжийн үйлчилгээг төрөөс үзүүлж байгаа ч төсөв, санхүүгийн хязгаарлалтаас хамааран хүрээ багатай байна.

2.3. Эдийн засгийн төлөв байдал

Сумын эдийн засгийн үндсэн салбар нь мал аж ахуй юм. 2024 оны байдлаар суманд ойролцоогоор 102900 толгой мал тоологдсон байна. Малын гаралтай бүтээгдэхүүн болох ноос, мах, сүү зэргийг дотоодын хэрэгцээнд ашиглаж, зарим хэсгийг зах зээлд борлуулдаг.



Хөдөө аж ахуйн салбар сүл хөгжсөн бөгөөд усалгаатай тариалангийн боломж хязгаарлагдмал байна. Гэвч зарим өрхүүд хүлэмжийн жижиг аж ахуй эрхэлж эхлээд байна.

Сумын нутаг дэвсгэрт ашигт малтмалын хайгуул хийгдэж байсан ч тогтвортой олборлолт хийгдээгүй. Уул уурхайн үйл ажиллагаанд нутгийн иргэдийн дунд эсэргүүцэл байдаг бөгөөд байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөг ихээр анхаарч байна.

Дэд бүтцийн хувьд сумын төвлөрсөн хэсэг төвийн эрчим хүчний сүлжээнд холбогдсон боловч зарим багуудад цахилгаан тасалдал байсаар байна. Ус хангамж нь голчлон гүний худаг, булаг шандын усаар хангагддаг ч ундны усны хүрэлцээ хязгаарлагдмал байна.

Ажил эрхлэлтийн хувьд ажиллаж буй иргэдийн дийлэнх нь малчид бөгөөд сар бүрийн тогтмол орлоготой иргэдийн тоо цөөн. Сумын дундаж өрхийн орлого улсын дунджаас доогуур үзүүлэлттэй байна.

3. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

ISO 14001:2016 байгаль орчны удирдлагын тогтолцооны стандартын дагуу компанийн зүгээс байгаль орчны гүйцэтгэлийг сайн байлгах зорилгоор байгаль орчны асуудлууд тэдгээрээс улбаатай байгаль орчны нөлөөллүүдийг тодорхойлж эрсдэлийн үнэлгээ хийхээр төлөвлөж байна. Эрсдэлийн үнэлгээ нь байгаль орчны гол асуудлыг зөв таньж тодорхойлоход дөхөм болсноор компани байгаль орчны чиглэлээр хийх ажлын ач холбогдлын эрэмбэ дарааллыг тодорхойлон гаргах, цаашдаад аль чиглэлд илүү анхаарах шаардлагатай зэрэг нь тодорхой болох юм.

3.1. Эрсдэлийн үнэлгээг эрсдэлийн матриц

ISO 14001:2016 стандартын дагуу байгаль орчны гүйцэтгэлийн ач холбогдлын дарааллыг тодорхой болгох зорилгоор эрсдэлийн үнэлгээ хийсэн. Байгаль орчны асуудлыг тодорхойлж эдгээртэй холбоотой байгаль орчны нөлөөллийг тодорхойлсон. Нөлөөлөл тус бүрийн эрсдэлийн зэргийг тодорхойлсон.

Хүснэгт 1. Эрсдэлийн үнэлгээний матриц.

Магадлал	Үр дагавар				
	Маш бага	Бага	Дунд	Их	Маш их
I Бараг болохгүй	L	L	M	H	H
II Болох магадлалтай	L	L	M	H	E
III Болох боломжтой	L	M	H	E	E
IV Болно	M	H	H	E	E
V Гарцаагүй болно	H	H	E	E	E



Хүснэгт 2. Магадлалын үнэлгээний шалгуур.

Түвшин	Зэрэг	Тайлбар
I	Бараг болохгүй	Онцгой нөхцөлд эрсдэлтэй байж магадгүй (<5%)
II	Болох магадлалтай	Заримдаа эрсдэлтэй байж магадгүй (5-20%)
III	Болох боломжтой	Заримдаа эрсдэл үүснэ (20-50%)
IV	Болно	Бараг бүх нөхцөл эрсдэл үүсгэж болзошгүй (50-70%)
V	Гарцаагүй болно	Бараг бүх нөхцөл эрсдэлтэй (70-100%)

Хүснэгт 3. Үр дагаврын үнэлгээний шалгуур.

Зэрэглэл	Уршиг	Эрсдэлд өртөгч ба эрсдэлийн тодорхойлолт		Уршгийг бууруулах арилгах шийдэл
		Хүн ам	Эд хөрөнгө	
I	Маш бага	Техноген нөлөө арилахад хор уршиг арилна	Хохирол үгүй	Тусгай шийдэл шаардлагагүй
II	Бага	Бүс нутагт хуримтлагдах нөлөөлөл бий болгож био орчинд стресс учруулна	Багавтар хохирол	Уламжлалт арга хэмжээ, одоогийн горимыг мөрдөх
III	Дунд	Урт хугацаанд дэлхийн дулааралд хувь нэмэр оруулна	Дунд зэрэг хохирол	Уламжлалт арга хэмжээ, одоогийн чанд горимыг мөрдөх, зохион байгуулалтын өндөр түвшинд ажиллах
IV	Их	Хуримтлагдах сөрөг нөлөө үүсгэж урт хугацаанд экологийн тэнцвэр алдагдана	Их хохирол	Орчин үеийн технологи, өндөр сонор сэрэмж, зохион байгуулалтын хоршил, тодорхой хэмжээний хөрөнгө зардал шаардана
V	Өндөр	Байгаль орчинд эргэж буцахааргүй уршиг учруулж экологийн тэнцвэрт байдал алдагдахад хүрнэ	Маш их хохирол	Орчин үеийн технологи, өндөр сонор сэрэмж, зохион байгуулалтын хоршил. Их хэмжээний хөрөнгө оруулалт шаардана



3.2. Эрсдэлийн үнэлгээний хүснэгт

Д/д	Болзошгүй аюул осол	Боломжит/Болзошгүй нөлөөлөл	Үр дагавар	Тохиолдох магадлал/давтамж	Эрсдэлийн үнэлгээ
1	Газар хөдлөл: Дорноговь аймаг нь газар хөдлөлтийн 5 баллын идэвхтэй бүсэд оршдог.	Хүний амь нас, эрүүл мэнд эрсдэх, уурхайн хана, овоолго нурах, дэд бүтцийн барилга байгууламж эвдэрч сүйдэх	Ноцтой	Бага	Дунд
2	Аянга цахилгаан	Гал түймэр гарах, түлш, шатах тослох материал тэсэрч дэлбэрэх, хүний амь нас эрсдэх аюултай. Цахилгаан хуваарилах байгууламж, трансформаторын систем, агаарын шугамууд, түлшний агуулах хамгийн өндөр эрсдэлтэй объектуудад тооцогдоно	Онц ноцтой	Бага	Их
3	Эрдэнэ сум орчмоор манай орны бусад нутгийн нэгэн адил хойд, баруун хойд зүгийн салхи зонхилж, жилийн дундаж хурд нь 4.0 м/с, их утга нь хавар, намрын улиралд 5.1 м/с хүрдэг ба өвөл бага утга нь ажиглагдана.	Их хэмжээний тоос нь уурхайн техник, тоног төхөөрөмжүүд, тэдгээрийн сэлбэг хэрэгслүүдийн насжилтыг багасгана (төхөөрөмжийн тоосны шүүлтүүр солих хугацаа богиносж, эд ангид тоос тогтон эвдрэл үүсгэнэ). Байгалийн шороон шуурга нь говийн бүсэд хавар идэвхэждэг бөгөөд энэ тохиолдол онц байдал зарлаж ү/а-г бүрэн зогсооно. Үзэгдэх орчин хязгааралдагдсанаар аваар, осол гарах нөхцөл бүрдэнэ. Хүчтэй шороон шуурга салхи нь ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдалд нөлөөлж, үйлдвэрлэлийн үйл ажиллагааг зогсоох, хаягдлын овоолго нурах аюултай.	Дунд зэрэг	Болзошгүй	Дунд



4	Гал түймэр	Төсөл хэрэгжих бүс нутаг нь цөлжүү хээрийн бүсэд орших бөгөөд ойн сан бүхий газар байхгүй тул байгалийн гаралтай түймэр гарах магадлал бараг байхгүй. Гол төлөв дэгдэмхий болон шатамхай бодис хадгалагдаж буй газруудад гал гарах магадлалтай. Үүнд: ШТМ-ын агуулах, тэсрэх бодисын агуулах, ажилчдын байр сууц, шатахуун түгээх станц, цахилгаан үүсгүүрийн байр, уурхайн баяжуулах үйлдвэр, химийн бодисын агуулах зэрэг орно.	Ноцтой	Болзошгүй	Их
5	Хаягдлын болон бага агуулга бүхий хаягдлын овоолго нурах	Налуугийн тогтворжилт алдагдах, хүчиллэг урсац бий болох, ажилчид гэмтэх, хүчиллэг урсцын улмаас хүнд металлууд хөрсийг бохирдуулах	Дунд зэрэг	Бага	Бага
6	Шатах тослох материал алдагдах	Хөрсний бохирдол үүсгэх, хөрсөөр дамжин гүний усанд нэвчин гүний усыг бохирдуулах, Хөрсний организмуудын амьдрах орчин сүйдэх	Дунд зэрэг	Болзошгүй	Дунд
7	Автомашины осол	Уурхайн үйл ажиллагаа, олборлолтод ашиглагдаж буй хүнд, хөнгөн машин механизмын аваар ослын улмаас хүний эрүүл мэнд, амь нас хохирох	Дунд зэрэг	Болзошгүй	Дунд
8	Техник, тоног төхөөрөмжүүд эвдрэх	Техник жолоочийн хяналтаас түр гарсны улмаас техник юм мөргөж жолооч гэмтэх	Дунд зэрэг	Болзошгүй	Дунд



4. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Тус байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь “Мандговь” ХХК-ийн Шартолгойн алтны үндсэн ордыг ил ба далд аргаар ашиглах төслийн үйл ажиллагаанд байгаль орчны нийцлийг хангуулах гол зорилготой.

Төлөвлөгөөний хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлэхийг зорилт болгоно. Үүнд:

- ISO 14001 байгаль орчны удирдлагын тогтолцооны элементүүдийг хэрэгжүүлэх
- Байгаль орчны аудит, БОННУ-ний шаардлагуудыг биелүүлэх
- Компанийн стратеги төлөвлөгөө, бизнес төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах
- Гэрээт байгууллагуудын байгаль орчны чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлж, түүний гүйцэтгэлд хяналт тавих, аргазүйн зөвлөгөөгөөр хангаж ажиллах,
- Уурхайн үйл ажиллагааны талбайн хүрээнд байгаль орчны хуулийн нийцлийг хангуулахад анхаарч ажиллах
- “Мандговь” ХХК-ийн уурхайн хэмжээнд байгаль орчны бодлогын хэрэгжилтийг хангах
- БОМТ-нд тусгасан үйл ажиллагааны чиглэлүүдийн хэрэгжилтийг хангаж, байгаль орчны асуудлыг тодорхойлох
- ОХШХ-нд талуудын оролцоог хангах, ил тод нээлттэй байх зарчмыг баримтлах.

2025 оны БОМТ-ны хэрэгжилтийг хангах мөн сөрөг нөлөөллийг буруулах чиглэлээр үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр нийт 18.6 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн ба дэлгэрэнгүй зардлын задаргааг доороос харна уу.



4.1. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал	Тоо хэмжээ	Нийт зардал, /төг/	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9
Агаарын чанар	Хөрс хуулалт, барилга байгууламж барих, элс олборлох, тээвэрлэх, овоолго үүсгэх зэргээр тоосжилт үүсч төсөл хэрэгжих орчны агаарын чанарт сөргөөр нөлөөлж, улмаар хүний эрүүл мэндэд сөргөөр нөлөөлнө.	Уурхайн авто замуудыг дулааны улиралд болон тоос ихээр босох үед усалгаа хийж чийгшүүлэх зэрэг арга хэмжээг авч хэрэгжүүлэх, 10 м/с ээс дээш салхитай үед газар шорооны ажил хийхгүй байх				Үйл ажиллагааны зардлаас	Салхи ихээр босдог хавар, намрын улиралд 7 хоногт 1-2 удаа	MNS ISO4227-2002, “Хүрээлэн буй орчны агаарын чанарын хяналтын төлөвлөгөө” MNS4585-2016
	Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах тээврийн хэрэгсэлүүдийн орчны агаарт бий болгох бохирдлыг багасгах үүднээс тэдгээрт засвар үйлчилгээг тогтмол хийх, чанар сайтай шатах тослох материал хэрэглэх.	Бүх машинд				Үйл ажиллагааны зардлаас	Жил бүр	“Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” MNS5885-2008



Гадаргын ба газрын доорхи усны нөөц	Ажилчдыг MNS 900:2005 стандартын шаардлага хангасан усаар хангана.	Энгийн найрлагатай тэсрэх бодисын үйлдвэр агуулах				Үйл ажиллагааны зардлаас	Үйл ажиллагаа явуулж байх үед	БОНБНУ
	Уурхайн үйл ажиллагааны явцад газрын доорх усны хэт ашиглалтаас үүдэн тухай орчмын газрын доорх усны түвшин буурах	Уурхайн усны ашиглалтыг тогтмол хянах, уурхайн талбайд гүний худаг гаргасны дараагаар худгийг тоолууржуулах, тайлан гаргах				Үйл ажиллагааны зардлаас	Жил бүр	БОНБНУ
Хөрсөн бүрхэвч	Шатах тослох материал болон нефтийн бүтээгдэхүүний асгаралтаас хөрс бохирдож болзошгүй.	Нефтийн бүтээгдэхүүн хадгалах технологийн горимыг чанд даган мөрдөж ажиллах, асгаралт болсон тохиолдолд саармагжуулах арга хэмжээг авах, саармагжуулах хэрэгслийг төслийн талбайд бэлэн байлгах	1 удаа цааш ид засварлах		2 сая ₮	2 сая ₮	Үйл ажиллагааны түршид	“Байгаль хамгаалал. Хөрс. Хот суурин газрын хөрсний ариун цэврийн үнэлгээний үзүүлэлтийн норм” MNS4919-2000,
	Олон салаа зам гаргахаас урьдчилан сэргийлэх дотоод замын 2 талаар тэмдэг, тэмдэглэгээ хийх	Энгийн найрлагатай тэсрэх бодисын үйлдвэр агуулах	ш	20	10	200,000	Тухайн жилд	БОНБНУ 108
Газрын хэвлий	Газрын хэвлийд далд малталт, хүдэр нураалтаас үүсэх орон	Далд уурхайн хаалт MNS 6296 : 2011				Үйл ажиллагааны	Уурхай ашиглалтын дараа	“Газар шорооны ажлын үеийн үржил шимт



	зай нь газрын гадаргад цөмрөлт хotoйлт үүсгэх магадлалтай	стандартын дагуу хийж гүйцэтгэх				зардалд тусгах		хөрс хуулалт, хадгалалт” MNS6296:2011,
Ургамлан нөмрөг	24.06 га талбайн ургамлан нөмрөг дарагдаж, үндсэн хэв шинжийг алдах	Уурхайн ажилчдын тосгоны нийт талбайн 10% болох 0.5 га талбайг зүлэгжүүлэх	ш	100	50,000	5 сая ₮	Жилд 1 удаа	“Уул уурхайн үйлдвэрийн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт” MNS5916-2008,
Амьтны аймаг	Уурхайн тэсэлгээний үед үүсэх дуу чимээ болон чичиргээ доргилтоос тухайн нутгийн зэрлэг амьтдад шууд физик үйлчлэл, техногенезийн стресс үүсэх, бэлчээр, тэжээлийн хомсдол гарах зэрэг сөрөг нөлөөлөл үзүүлнэ	Уурхайн үйл ажиллагааг шөнийн цагаар аль болох явуулахгүй байх, суурин ашиглагдах техникүүд богино зайн гэрлээ ашиглах хэрэгтэй				Үйл ажиллагааны зардалд тусгах		БОНБНУ
Нийт						7200000		



4.2. Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, /төг/	Нийт зардал, /төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8
Техникийн нөхөн сэргээлт	Төлөвлөхгүй						
Биологийн нөхөн сэргээлт	Төлөвлөхгүй						
Орчны тохижилт	Хатуу хаягдлыг ахуйн гарал үүслээр нь ялган ангилж, хураан хуримтлуулах зориулалтын цэгт хогийн сав байршуулах	Дотоод төлөвлөлтөөр					
Нийт							



4.3. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, /төг/	Нийт зардал, /төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8
Археологийн дурсгал, Палентологийн дурсгал	Түүх, соёлын өвийн дурсгалт зүйл илрээгүй байгаа болно	ЭНТБҮА-ын орчин					
Нийт							

4.4. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Нөлөөллөөс зайлсхийх арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж
Газар хөдлөлт	Зохих зураг төслийн стандартыг ашиглан гүйцэтгэгч байгууллагад шаардлага тавих, байгууламжийг улсын комисст хүлээлгэн өгөх	Төслийн талбай	Уурхайн төлөвлөлтөөр дотоод	Төсөл эхлэхийн өмнө нэг удаа
Аянга цахилгаан	Аянга зайлуулагчийг ЦС-ын байгууламжийн ойролцоох өндөрлөг газруудад суурилуулах. ЦС-ын цахилгаан гүйдэл бүхий тоноглолуудыг	Төслийн талбай		Төсөл эхлэхийн өмнө нэг удаа



	бүгдийг нь стандартын дагуу газардуулсан байх			
Аадар бороо	Барилга байгууламжуудын зураг төсөл, чанарт цаг агаарын нөхцөлүүдийг тусгах, уурхайг үерээс хамгаалсан далан байгууламжтай болгох	Төслийн талбай		Төсөл эхлэхийн өмнө, нэг удаа
Шороон шуурга	Уурхайд онцгой байдлын журам боловсруулан мөрдөж ажиллах	Төслийн талбай		Төслийн хугацаанд байнга
Халдварт өвчин	Өндөр эрсдэлтэй амьтадтай (шувууд) харьцахгүй байх хангалттай хэмжээний хамгаалалтын хэрэгсэлтэй байх (амны хаалт гэх мэт)	Төслийн талбай		Төслийн хугацаанд, жил бүр
Нефт болон химийн аюултай бодис асгарах	Ашиглалт, тээвэрлэлт, хадгалалт зэрэгт анхаарал хандуулж холбогдох журам боловсруулан мөрдөж ажиллах шаардлагатай.	Төсөл хэрэгжих бүс нутаг		Төслийн хугацаанд байнга

4.5. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, /төг/	Нийт зардал, /төг/	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
	Ахуйн	Уурхайн ахуйн хатуу хог хаягдалд хоол хүнс, түлш, угаалга цэвэрлэгээний материалын сав,	Уурхай орчин			Үйлдвэрлэлийн зардалд	Тогтмол	БОННҮНТ



		баглаа боодол болох мод, цаасан хайрцаг, хуванцар болон шил сав, гялгар уут зэрэг материалуудыг цуглуулаад хуванцар, шил, төмөр ба бусад төрлөөр нь хуваан ангилж, цааш ашиглах боломжгүй хог хаягдлыг зөвшөөрөгдсөн цэг рүү зөвшөөрөлтэй ААН-ээр зайлуулуулах,						
		Ахуйн хог хаягдлыг ангилж зориулалтын хогийн саванд хадгалах	Уурхай орчин			Үйлдвэрлэлийн зардалд	Тогтмол	
		Халдваргүйжүүлэх, нян устгах ариутгалыг орон нутгийн мэргэжлийн байгууллагаар хийлгэх,	Уурхай орчин			Үйлдвэрлэлийн зардалд	Тогтмол	
	Уурхайн	ШТМ-ын хаягдлыг битүүмжлэл сайтай хадгалж байгаад хаягдал тос боловсруулах үйлдвэрт тушаах	Уурхай орчин		1,500,000	Үйлдвэрлэлийн зардалд	Тогтмол	БОНБНУ
		Хатуу хаягдлыг ахуйн гарал үүслээр нь ялган ангилж, хураан хуримтлуулах зориулалтын цэгт хогийн сав байршуулах	Уурхай орчин	1 Ширхэг	600,000	600,000		
	Аюултай	Аюултай хог хаягдал тээвэрлэх, хадгалах, устгах үйл ажиллагаа эрхэлдэг эрх бүхий нэгж байгууллагатай гэрээ байгуулан нийлүүлэх,	Уурхай орчин			Үйлдвэрлэлийн зардалд	Жилд 1 удаа	
	Нийт					2,100,000		



4.6. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа	Давтамж ийн тоо	Нэгжийн зардал, /төг/	Нийт зардал, /төг/	Тайлб ар	Баримтла х эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8
Агаар дахь хорт хийн агууламж	-Мониторингийн цэг буюу нөлөөлөлд өртөөгүй газар -Уурхайн камп	<u>2 болон 4-р улиралд</u>	Жилд 2 удаа	350000	700000		
Агаар дахь тоосонцорын хэмжээ /PM ₁₀ /	-Уурхай орчим	<u>2 болон 4-р улиралд</u>	Жилд 2 удаа				
Хөрсний хими чанар	Уурхай бүс, камп орчимд	<u>2 болон 4-р улиралд</u>	Жилд 2 удаа	250000	500000		БОНБНУ
Усны чанар	Үйлдвэрийн ундны ус	<u>2 болон 4-р улиралд</u>	Жилд 2 удаа	250000	500000		БОНБНУ
Бэлчээрийн төлөв байдал ургамлан нөмрөг	Төслийн нөлөөллийн талбайд	<u>2 болон 4-р улиралд</u>	Жилд 2 удаа	100000	200000		БОНБНУ
Нийт					1,900,000		



5. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь			Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
			2025 он				
			Сар ...	Сар ...	Сар ...		
	1	2	8	9	10	6	7
1	Хавар (5 сар), намар (10 сар) байгаль орчныг хамгаалах, ялангуяа ус, хөрс, ургамлыг хамгаалахтай холбогдсон сургалтыг өөрийн ажиллагсдын дунд зохион байгуулж дүгнэж байх.	400,0	-	-	-	Уурхайн удирдлага	-
2	Болзошгүй аюул ослын үед орон нутгийн эмнэлэг бусад байгууллагатай хамтран ажиллах.	300,0	-	-	-	Уурхайн удирдлага	-
3	Байгаль хамгаалах талаар сурталчилгаа зохион байгуулах.	400,0	-			Уурхайн удирдлага	-
4	Ариун цэвэр, эрүүл ахуй, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны чиглэлээр сургалтыг системтэй зохион байгуулах.	400,0	-			Уурхайн удирдлага	-
5	Хатуу, шингэн хог хаягдлыг битүү саванд хуримтлуулж тухай бүрд нь хогийн цэгт хаях, ариутгах бие засах газрыг хлорын шохойн 5-10 %-ийн уусмалаар ариутгаж байх	1000,0	-			Уурхайн удирдлага	-
6	Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг талуудад тайлагнах төсөв	400,0				Компанийн захиргаа	
7	Уурхайн эдэлбэр газар дотроос түүх дурсгалын болон ямар нэгэн нэн ховор олдвор олдвол газар шорооны ажлыг зогсоож мэргэжлийн байгууллагад хандан яаралтай арга хэмжээ авна	400,0				Уурхайн удирдлага	



8	Дүйцүүлэн хамгаалах нөхөн сэргээх ажлын хүрээнд орон нутгийн удирдлагатай хамтран ажиллана	3,600,0				Компанийн захирга	
9	Хог хаягдлын гэрээ байгуулан ажиллаж хог хаягдлын төлбөр төлөх	500,0				Уурхайн удирдлага	
Нийт		7,400.0					

6. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ

	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, /төг/	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ажилтан	Зохион байгуулах газар
	1	2	3	4	5	6	7
	Уурхайн удирдлага, Эрдэнэ сумын ЗДТГ, Иргэд	Хурал болон цахим хэлбэрээр	Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлт	2025 оны IV улиралд	Үйл ажиллагааны зардалд	Байгаль орчны хэлтэс	Эрдэнэ сум болон цахим орчинд
	Нийт				-		



7. Эрсдэлийн талаар хэрэгжүүлэх хөтөлбөр

7.1. Аюулгүй ажиллагаа

Уурхайн бүх ажил үйлдлүүд нь “Уурхайн аюулгүй ажиллагааны дүрэм”-ийн дагуу явагдах бөгөөд түүнийг хатуу чанд мөрдөж, доорх тусгай арга хэмжээнүүдийг биелүүлж байж үйлдвэрийн аюулгүй ажиллагаа эрсдэлийг хангах ёстой.

Үүнд:

1. Үйлдвэрлэлийн осол гэмтэлтэй тэмцэх
2. Уурхай дахь тоосжилттой тэмцэх
3. Тэсэлгээний үеийн аюулгүй ажиллагаатай тэмцэх

Уурхайн хажуу догол, овоолгыг тогтвортой байлгахын тулд доорх арга хэмжээ авч явуулна.

Үүнд:

1. Овоолгын талбайг байнга тэгшлэн, арчилж байхаас гадна овоолгыг цас, бороо, үер уснаас хамгаалах шуудуу руугаа $I=0.005-0.007$ -ийн налуутай байгуулах.
2. Уурхайг цас, бороо, үерийн уснаас хамгаалах усны шуудууг ус орж ирэх боломжтой бүх талаас нь татан хамгаалсан байх.

7.2. Уурхайн ба үйлдвэрийн тоног төхөөрөмжийн аюулгүй ажиллагаа эрсдэлийг талаар тавих шаардлага, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Уурхайн үйл ажиллагаа ба үйлдвэрийн цогцолборын үйлдвэрлэлд хэрэглэгдэх машин механизм, тоног төхөөрөмжүүд нь ажлын байр, хүрээлэн байгаа орчныг бохирдуулахгүй байхын зэрэгцээгээр аюулгүй ажиллагааны шаардлага хангасан байх ёстой.

Үүнд:

- Тоног төхөөрөмж бүр технологийн горимд нийцсэн буюу уг үйлдвэрлэлийн зориулалттай байх
- Тоног төхөөрөмж нь тус бүрдээ ашиглалтын заавар, паспорттай байх
- Тоног төхөөрөмжийн хяналт хэмжилтийн багажууд нь улсын стандарт хэмжил зүйн албаар заавал баталгаажуулагдсан байх
- Тоног төхөөрөмж нь аливаа засвар үйлчилгээ хийхэд тохиромжтой байрлал нөхцөлөөр хангагдсан байх

7.3. Үйлдвэрлэлийн осол гэмтэлтэй тэмцэх арга хэмжээнүүд:

- Үйлдвэрлэлийн ажил явуулах явцад техник аюулгүй ажиллагааны дүрмийг хатуу мөрдөж, хүн бүрийг сургасан байх.
- Нурал, уулын малталт зэргээс хамгаалсан хаалт хамгаалалтыг цаг тухайд нь хийж, тавьж байх.



- Автомашин болон тээврийн бусад хэрэгсэл овоолго дээрээй члуулгийн гулсах зурвасын гадна хүрээнд зогсон ачаагаа буулгах.
- Бульдозерын овоолгын ирмэгийн тавцан нь төв рүүгээ 2⁰-аас доошгүй налуутай байхаас гадна ирмэгийн уртын дагууд 0.7 м–ээс доошгүй өндөр, 1.5 м–ээс доошгүй өргөнтэй шороон хамгаалалттай байх.
- Уулын ажлыг уурхайн ашиглалтын мэргэжлийн хүний удирдлага дор явуулах.
- Үйлдвэрийн ослоос урьдчилан сэргийлэх аюулгүй ажиллагааны талаар ажилчдад тогтмол зааварчилгаа өгч байх.

7.4. Галын аюулгүй ажиллагаа:

Галын аюулгүй байдлыг хангах, дотоод дүрмийг сахих, гал унтраах тоног төхөөрөмжийг хэвийн ажиллагаатай байлгах, тэдгээрийг ажиллагсдад ашиглуулж сургах, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны гурван шатны үзлэгт хамруулах

1. Ээлж, бригадад
2. Байгууллагын доторх нэгж, хэсгүүдэд
3. Байгууллагыг бүхэлд нь

- Галын аюулгүй ажиллагааны болон эрүүл ахуйн тодорхой нөхцөлд баталгаажаагүй, эсвэл журмын дагуу үйлдвэрлээгүй шинэ бодис, материалыг үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжийн хийцэд хэрэглэхийг хориглох.

- Ил уурхай ба үйлдвэрийн машин, тоног төхөөрөмж нь хэвийн ажиллагаагаа алдах үед анхааруулах дохио өгөх, аваар гарах, аюулд хүргэж болзошгүй горимоор ажиллах тохиолдолд автоматаар унтрах, хөдөлгүүр болон цахилгааны эх үүсвэрээс салгагдах хэрэгсэлтэй байх.

- Тоног төхөөрөмжийн ажил гүйцэтгэх хэсэг, эд ангиуд нь тэдгээрийг ажиллуулах эрчим хүчний эх үүсвэр /цахилгаан гүйдэл, шахагдсан хий гэх мэт/ тасарснаас үүсэх аюул ослоос урьдчилан хамгаалах, эрчим хүчний эх үүсвэрийг дахин залгах үед өөрөө залгагдахгүй хэрэгслээр хангагдсан байхаар тоноглогдсон байх.

7.5. Хөдөлмөрийн аюулгүй байдал

Хөдөлмөрийн процесст хүний ажиллах чадвар, эрүүл мэндийг хэвээр хадгалж, аюулгүй ажиллагааг хангаж чадах нөхцөлийг бий болгоход чиглэсэн хууль тогтоомж, нийгэм эдийн засаг, зохион байгуулалт, техник, ариун цэвэр, эрүүл ахуйн цогцолбор арга хэмжээ авах нь хөдөлмөр хамгааллын гол зорилго юм.

Хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны стандарт боловсруулан мөрдөж, дотоод хяналт шалгалтыг хүчтэй болгон зааварчилгааг тогтмолжуулснаар аваар осол, эрсдэлгүй ажиллах боломж бүрдэнэ. Цаашид хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм, заавар, журам боловсруулж бүх ажилчдад танилцуулахаас гадна доорх дүрэм, стандарт, зааврыг үйлдвэрлэлд мөрдлөг болгон ажиллана.

- Хөдөлмөрийн эрүүл мэнд, аюулгүй байдлын удирдлагын тогтолцоо. Шаардлага. MNS OHSAS 18001:2012 стандартын дагуу ажиллах.



- Ажлын байрны дуу шуугианы хэмжээ нь УСТ-12-1-008-85 /MNS/-д заасан шаардлагыг хангасан байх.
- Дуу шуугиантай орчинд ажиллагсдад чихэвч хэрэглүүлэх ба ажлын дэглэм тогтоон ажиллуулах зэргээр чих дүлийрэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах
- Ажлын байранд байгалийн гэрэлтүүлгийн итгэлцүүр 1.5 хувиас багагүй байна. Гэрэлтүүлэг нь ажлын талбарт жигд тархсан гялбалт үүсэхгүй байх шаардлагатай ба гэрэлтүүлэгчийн үүсвэрийг тогтмол хугацаанд байнга цэвэрлэж байх
- Ажлын тусгай хувцас, хамгаалах хэрэгсэл нь тухайн ажил мэргэжлийн онцлогт тохирсон материалаар хийгдсэн, хэв загвар нь аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн шаардлага хангасан байна.
- Ажлын тусгай хувцасны чанарын үзүүлэлтийн жагсаалт УСТ-0012.4016.89/ /MNS/-ийг баримтлан ажлын хувцас хамгаалах хэрэгслийн жагсаалт, эдэлгээний хугацааг баталсан тогтоол шийдвэр гаргах ёстой. Ажлын хувцас, хамгаалах хэрэгслийг шаардлагын дагуу угаах, ариутгах, цэвэрлэх нөхцөл боломжийг ажил олгогч хангасан байна.



8. ХАВСРАЛТ

Хууль зүйн сайдын 2016 оны
А/204 дүгээр тушаалаар батлав.

МОНГОЛ УЛС
ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН
УЛСЫН БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ
000174627

2008.01.24
/ Бүртгэсэн он, сар, өдөр /

9011130143
/ Хувийн хэргийн дугаар /

2861852
/ Регистрийн дугаар /

Мандговь Хязгаарлагдмал хариуцлагатай компани
/ Хуулийн этгээдийн нэр, хариуцлагын хэлбэр /

Дүрэм
/ Үүсгэн байгуулах баримт бичиг /

Шийдвэр 1 2004.12.08
/ шийдвэрийн нэр / / дугаар / / он, сар, өдөр /

4610 Гадаад худалдаа
/ код / / Үндсэн эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

Туслах эрхлэх үйл ажиллагааны чиглэл /

Хугацаагүй 3 4,521,618.3
/ хугацаа / / гишүүдийн тоо / / өөрийн хөрөнгийн хэмжээ, мянган төгрөгөөр /

Улаанбаатар, Сүхбаатар, 1-р хороо, олимп, Монгол 3000 ХХК-н байр 2-р давхар, Утас1: 311946, Утас2: ,
Факс:
/ хуулийн этгээдийн албан ёсны хаяг /

 Улсын бүртгэлийн ерөнхий газар
Хуулийн этгээдийн улсын
бүртгэлийн газар
/ бүртгэсэн байгууллагын нэр /

Гэрчилгээ дахин олгосон 2018 он 11 сар 21 өдөр



Хуулийн этгээдийн үүсгэн байгуулах баримт бичигт оруулсан нэмэлт өөрчлөлтийн бүртгэл

Д/д	Нэмэлт өөрчлөлтийн агуулга	Бүртгэсэн	
		Огноо	Ажилтан тэмдэг
1	Цэрэндаваа овоотой Баатарбилэг-г Гүйцэтгэх захирал-р томилсныг бүртгэв. Дахин гэрчилгээ олгов.	2018.11.20	Ж.Оюунгаа
2		2018.11.21	Ж.Оюунгаа
3	Хувьцаа эзэмшигч 2 хасагдаж хувьцаа эзэмшигчийн тоо нийт 1 болж өөрчлөгдсөнийг бүртгэв.	2020.02.10	Э.Эрдэнэбилэг

Энэхүү гэрчилгээг хуурамчаар үйлдсэн этгээдэд Монгол Улсын хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.
Улсын бүртгэлийн гэрчилгээ засвартай бол хүчингүй.



* 0 0 0 1 7 4 6 2 7 *



GREENTRENDS
ENVIRONMENTAL SERVICES

МАНДГОВЬ ХХК-ИЙН ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЭРДЭНЭ СУМЫН
НУТАГТ ОРШИХ MV-017585 ТООТ АШИГЛАЛТЫН ТУСГАЙ
ЗӨВШӨӨРӨЛТЭЙ ШАРТОЛГОЙН АЛТНЫ ҮНДСЭН ОРДЫГ ИЛ
БА ДАЛД АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ
ТӨЛӨВ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Улаанбаатар хот
2018 он



Ашигт малтмал, газрын тосны газрын даргын
2022 оны 12 дугаар сарын -ны өдрийн
..... дүгээр тушаалын хоёрдугаар хавсралт



Батлав:

Мандговь ХХК-ийн захирал /Ц.Баатарбилэг/




Хүлээн авсан:

АМТГ-ын Уул уурхайн хэлтсийн дарга /Т.Зууннаст/

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН ЭРДЭНЭ СУМЫН
УЛААН ЧУЛУУ ОРДЫН 2025 ОНЫ
УУЛЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ**



Ашигт малтмалын төрөл: Алт (Үндсэн)
Үндсэн АТЗ-ийн дугаар: MV-017585
Нэмэлт АТЗ-ийн дугаар:



Танилцсан: Уул уурхайн хэлтсийн ахлах мэргэжилтэн

[Signature]

/П.Зоригт/

БОЛОВСРУУЛСАН:

1. Ерөнхий инженер
2. Уулын инженер
3. Баяжуулагч инженер
4. Механик инженер
5. Эдийн засагч

[Signature]

2025 он